

Бүртгэлийн материал

ITGEL INTERNSHIP WINTER COURSE JAN 2026 APPLICATION



Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (JICA)



Япон компанид дадлага ажил хийх замаар Монгол улсад өндөр ур чадвартай инженер бэлтгэх хөтөлбөр (ITGEL)

Өвлийн ээлж

Оюутнуудад зориулсан танилцуулга
уулзалтын материал

2025.4.22~30

Агуулга

1. Агуулга
2. Хөтөлбөрийн товч танилцуулга
3. Хөтөлбөрийн зорилго
4. Дадлага хөтөлбөрийн хэрэгжилтийн дараалал
5. Бэлтгэл сургалтын тухай (Япон хэл/Бизнесийн ёс зүй)
6. Японд дадлага хийх компаниудын тухай
7. Дадлагын жишээ
8. Зардал: Төслийн хариуцах болон оюутны хариуцах зардал
9. Холбоо барих
10. Бүртгэлийн материал




Хөтөлбөрийн товч танилцуулга

- Хөтөлбөрийн нэр Япон компанид дадлага ажил хийх замаар Монгол улсад өндөр ур чадвартай инженер бэлтгэх хөтөлбөр (ITGEL)
- Хэрэгжүүлэх хугацаа Бэлтгэл сургалт 6 сар (Монголд), дадлага 2~3 долоо хоног (Японд)
- Хамрагдах оюутны тоо Нийт 40 хүн (2 ээлж тус бүр 20 хүн)
- Хамрагдах сургууль МУИС, ШУТИС, ХААИС, ШУТИС-Коосэн, Монгол Коосэн, Шинэ Монгол Коосэн
- Хамрагдах мэргэжлүүд Инженерийн чиглэлийн анги (Барилга Архитектур, Механик, Цахилгаан Электроник, Биотехнологи, Мэдээллийн технологи гэх мэт)
※Шинжлэх ухаан, байгалийн шинжлэх ухааны чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын хувьд цаашдаа инженерээр ажиллах сонирхолтой бол хамрагдаж болно. (Жишээ нь: Хими, физик, математик, статистикийн анги гэх мэт)
- Хамрагдах оюутнууд 2026 оны 6 сард төгсөх оюутнууд
- Дадлага хийх компаниуд Гадаадын хүний нөөцийг ажиллуулах сонирхолтой компаниуд, орон нутгийн засаг захиргаа, худалдаа аж үйлдвэрийн танхим гэх мэт
- Ашиглах хэл Япон хэл

Хөтөлбөрийн зорилго

- Монголын аж үйлдвэрийн хөгжилд хувь нэмрээ оруулах **шилдэг инженерүүдийг бэлтгэх**
- MJEED (1000 инженер төсөл)-ын хувьд бол оюутнууд Японы их, дээд сургууль, техникийн коллеж төгссөний дараа эх орондоо буцан ирж Монголдоо ажиллах шаардлагатай байсан.
- Гэвч өндөр ур чадвартай инженер болохын тулд зөвхөн их дээд сургуульд суралцаад зогсохгүй өндөр түвшний инженерээр ажилласан туршлагатай (**good working experience**), практик ур чадвар эзэмшсэн байх шаардлагатай юм.
- Япон орон бол инженерүүдэд шаардлагатай **good working experience** хуримтлуулахад тохиромжтой орон.
- Японд дадлага ажил хийх, түүний дараа сургуулиа төгсөөд Японд тодорхой хугацаанд ажиллаад эх орондоо эргэн ирж Монголын аж үйлдвэрийн хөгжилд хувь нэмрээ оруулах шилдэг инженерийн **боловсон хүчнийг хөгжүүлэх** төсөл юм.



Дадлага хөтөлбөрийн хэрэгжилтийн дараалал



Бэлтгэл сургалтын тухай (Япон хэл/Бизнесийн ёс зүй)

- Өвлийн 2-р ээлжийн 30 орчим оюутанд зориулсан бэлтгэл сургалтыг **2025 оны 6-р сараас 2025 оны 11-р сар хүртэл нийт 6 сарын хугацаанд** зохион байгуулна.
- Сургалтын агуулгад "Япон хэлний сургалт", "Бизнесийн ёс зүйн сургалт" орно.
- "Япон хэлний сургалт"-ын зорилго нь Японд дадлага хийх хүртэл N3 буюу түүнээс дээш түвшний япон хэлний ур чадварыг эзэмшүүлэх. (хэрэв N3 түвшинд хүрээгүй тохиолдолд Японд дадлага хийх боломжгүй болно.)
- Сургалт долоо хоног бүрийн бямба гаригт танхимаар эрчимжүүлсэн сургалт, ажлын өдрүүдэд онлайн давталтын хичээл орохоор төлөвлөж байна.
- Японд дадлага хийх нь шийдэгдсэн оюутнуудад Японд дадлага хийх, ажиллахдаа мэдэх шаардлагатай бизнесийн ёс зүйн сургалтыг орно.

Японд дадлага хийх компаниуд

- Барилга Архитектур, Механик, Цахилгаан Электроник, Биотехнологи, Мэдээллийн технологи гэх мэт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Японы компаниуд.
- Гадаадын хүний нөөцийг ажиллуулах сонирхол бүхий компаниуд.
- ЖАЙКА-гийн Япон дахь дотоодын баазаар дамжуулан орон нутгийн засаг захиргаа, худалдааны танхимууд болон тэдний санал болгосон зорилтот компаниуд.
- Японы компаниуд ч гэсэн Монголоос чадварлаг оюутнуудыг ажиллуулах хүсэлтэй байгаа! Хамтдаа хөгжих орчинг бүрдүүлсэн тул та бүхэн сонирхоод үзээрэй!
- Дадлага хийх компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг компаниудын жагсаалтаас үзнэ үү.

Дадлагын жишээ

	Агуулга
1дэх өдөр	Оюутан өөрийгөө танилцуулах Компанийн танилцуулга/үйл ажиллагааны танилцуулга, уулзалт яриа хийх
2дэх өдөр	Үйл ажиллагааны дэлгэрэнгүй танилцуулга Оюутнуудын дадлага хийх сэдвүүдийн танилцуулга
3дэх өдөр~	Дадлагын хөтөлбөрийн үйл ажиллагаа Компанийн ажилтантай багаар ажиллах
8дэх өдөр	Завсрын тайлан
9дэх өдөр~	Дадлагын хөтөлбөрийн үйл ажиллагаа
Сүүлийн өдөр	Тайлангийн хурал

【Сэдвийн жишээ】

- Зах зээлийн судалгаа хийх
- Шинэ бүтээгдэхүүн санаачлах
- Програмчлал, аппликэйшн хөгжүүлэлт
- Бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн процессыг сайжруулах санаа гаргах
- Ажилчдын туршлагад үндэслэн ажлын үр ашгийг дээшлүүлэх санаа гаргах



Зардал: Төслийн хариуцах болон оюутны хариуцах зардал

Төслийн хариуцах зардал	Оюутны хариуцах зардал
● Бэлтгэл сургалтын зардал ● Онгоцны тасалбарын үнийн 50% ● Япон доторх тээврийн зардал ● Японд байрлах байрны зардал ● Дадлагын даатгал	● Онгоцны тасалбарын үнийн 50% ● Визний төлбөр ● Гадаадад аялах даатгал ● Бэлтгэл сургалтад хэрэглэх сургалтын материалын зардал гарах магадлалтай ● Цалингүй



Холбоо барих

Хэрэв танд асуулт байвал эхлээд их сургууль, коллежийн мэргэжлийн багштайгаа зөвлөлдөнө үү.

Илүү нэмж тодруулах зүйл байвал доорх хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Холбоо барих имэйл хаяг : itgel_info@asiaseed.org

Хариуцсан ажилтан : 山野井 真子 (Яманой Мако)

Asia Seed Монгол дахь оффис

Хариуцсан ажилтан: Пүрэвчулуун, Ундрах

Утас: 9910-3387 / 9311-7699

Бүртгэлийн хуваарь

STEP 1: Элсэлтийн материал хүлээн авах

<Эцсийн хугацаа: 2025.5.11 хүртэл>

STEP 2: 1-р шалгаруулалт: Харьяа сургуулийн сонгон шалгаруулалт.

STEP 3: 2-р шалгаруулалт: ЖАЙКА болон хөтөлбөрийн багийн сонгон шалгаруулалт.

STEP 4: Япон хэлний шалгалтанд оролцох оюутнуудад мэдэгдэх.

STEP 5: Эцсийн шалгаруулалт: Япон хэлний шалгалт.

STEP 6: Эцсийн хариу: **2025.6.4-с хойш.**

STEP 7: **2025.6.7-с** япон хэлний хичээл эхэлнэ.

1) Бүртгүүлэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж **2025.5.11**-ны өдөр хүртэл доорх имэйл хаяг руу явуулна уу.

- Элсэлтийн бүртгэлийн хуудас
- Бэлтгэл сургалтад бүртгүүлэх үедээ япон хэлний N4 түвшинтэй дүйцэхүйц япон хэлний мэдлэгийг харуулсан гэрчилгээ (Жишээ: JLPT, NAT-TEST, J-CAT гэх мэт)
- Эссэ (Word дээр бичих)

※Элсэлтийн бүртгэлийн хуудас болон эссэний загварыг дараах QR код эсвэл линкээс татаж авах боломжтой.

[ITGEL Internship Winter Course Application](#)



2) Дээрх 3 материалыг доорх файлын нэрээр хадгалж, нэг мэйлээр илгээнэ үү.

File name: 【Сургуулийн нэр_Бүртгүүлэгчийн нэр】

Жишээ: 【MUST_Uyanga】

Мэйлийн гарчиг: 【Itgel_Winter_University_Full Name】

Жишээ: 【Itgel_Winter_NUM_Uyanga Bat】

3) Бүртгэлийн бичиг баримтаа доорх имэйл хаягаар илгээнэ үү.

Илгээх и-мэйл: itgel_info@asiaseed.org

Сургуулийн нэр	Хариуцсан ажилтан	Имэйл хаяг
ШУТИС	※Тодорхой болхоор мэдэгдэнэ	itgel_info@asiaseed.org
МУИС	B.TSETSENTSOLMON	tsetsentsolmon.b@num.edu.mn
ХААИС	B. BAZARSAD	bazarsad@mul.edu.mn
ШУТИС коосэн	D.TUNGALAG	d.tungalag@must.edu.mn
Монгол коосэн	J.URANTSOOJ	urantsooj.j@mk.edu.mn
Шинэ Монгол коосэн	A.GANSUKH	gansukh.a@nmct.edu.mn